

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/8/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор хот 2022 оны 02 дугаар сар</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 80112188 Цахим хаяг: myangnboom@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/116

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	82,760,646.61	131,781,311.89
33	АВЛАГА	00.00	7,620,000.00
335	Бусад авлага	00.00	7,620,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	7,620,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	82,760,646.61	124,161,311.89
351	Түүхий эд материал	8,334,533.52	20,472,246.20
35110	Тусгай зориулалттай материал	7,989,583.52	17,559,746.20
35130	Эм боох материал	344,950.00	2,912,500.00
354	Хангамжийн материал	74,426,113.09	103,689,065.69
35410	Бичиг хэргийн материал	3,698,144.00	4,392,524.00
35420	Аж ахуйн материал	51,875,164.00	77,034,481.50
35440	Түлш, шатах тослох материал	66,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	2,615,300.00	1,155,000.00
35460	Хүнсний материал	1,381,255.10	1,008,310.20
35470	Бусад хангамжийн материал	14,790,249.99	20,098,749.99
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,516,225,160.67	1,469,520,464.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,516,225,160.67	1,469,520,464.71
392	Биет хөрөнгө	1,465,701,966.20	1,419,016,714.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,450,483,205.58	1,450,483,205.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	-51,853,955.96	-87,801,167.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	67,413,693.00	69,020,093.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,017,247.52	-32,177,041.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,630,427.46	42,509,534.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,954,156.36	-23,017,908.58
393	Биет бус хөрөнгө	50,523,194.47	50,503,750.03
39301	Програм хангамж	725,000.00	725,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-661,805.53	-681,249.97
39303	Бусад биет бус хөрөнгө	50,460,000.00	50,460,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,598,985,807.28	1,601,301,776.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,598,985,807.28	1,601,301,776.60
51	Засгийн газрын хувь оролцоо	1,598,985,807.28	1,601,301,776.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	164,218,577.00	164,218,577.00
51101	Өмч: - төрийн	164,218,577.00	164,218,577.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,114,686,137.83	1,117,002,107.15
51210	Өмнөх үеийн үр дүн	1,114,686,137.83	1,114,686,137.83
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,315,969.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	320,081,092.45	320,081,092.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,598,985,807.28	1,601,301,776.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	536,328,323.00	550,344,354.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,601,523.00	13,264,412.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,601,523.00	13,264,412.00
120017	Үнэ төлбөргүй орлого Үндсэн хөрөнгө		2,275,000
120018	Үнэ төлбөргүй орлого бараа материал		10,989,412
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,601,523.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	527,726,800.00	537,079,942.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	442,847,600.00	470,616,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	442,847,600.00	470,616,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,646,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,646,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,233,200.00	66,463,242.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,233,200.00	66,463,242.90
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	561,838,946.85	548,003,385.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	561,838,946.85	548,003,385.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	535,433,937.62	540,203,192.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	334,309,733.08	345,433,505.58
210101	Үндсэн цалин	270,363,233.08	277,829,623.75
210102	Нэмэгдэл	40,699,300.00	37,424,597.41
210104	Урамшуулал	23,247,200.00	30,179,284.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,020,900.00	46,250,700.00
210201	Тэтгэврийн даатгал	28,574,200.00	32,301,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,361,700.00	3,487,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,689,400.00	2,789,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	672,300.00	697,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,723,300.00	6,974,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,872,908.69	62,963,242.90
210301	Гэрэл, цахилгаан	3,114,672.93	2,268,921.96
210302	Түлш, халаалт	54,209,516.76	51,203,960.94
210303	Цэвэр, бохир ус	9,548,719.00	9,490,360.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,549,747.51	6,886,900.14
210401	Бичиг хэрэг	1,088,640.00	665,220.00
210402	Тээвэр, шатахуун	600,000.00	1,316,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,411,400.00	1,070,370.82
210404	Ном, хэвлэл	52,800.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,926,900.00	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,470,007.51	1,897,300.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,660,509.32
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	00.00	27,500.00
2105	Нормативт зардал	33,855,100.70	15,809,454.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	736,590.00	241,150.00
210502	Хоол, хүнс	33,118,510.70	15,206,404.90
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	361,900.00

**Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,000.00	7,574,700.00
210604	Урсгал засвар	33,000.00	7,574,700.00
2107	Томилолт, зочны зардал	168,000.00	160,900.00
210702	Дотоод албан томилолт	168,000.00	160,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,046,900.00	2,949,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	777,900.00	2,368,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	269,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	231,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,577,647.64	52,174,788.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,189,112.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,042,100.00	1,030,980.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,535,547.64	48,954,696.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,405,009.23	7,800,193.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,356,800.00	1,172,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	100,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,646,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	710,800.00	1,072,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,594,291.31	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,594,291.31	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,453,917.92	6,627,793.60
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,453,917.92	6,627,793.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-25,510,623.85	2,340,969.02
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	24,999.70
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	24,999.70
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-24,999.70
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-25,510,623.85	2,315,969.32

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,218,577.00	320,081,092.45	1,140,196,761.68	1,624,496,431.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,218,577.00	320,081,092.45	1,140,196,761.68	1,624,496,431.13
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-25,510,623.85	-25,510,623.85
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,218,577.00	320,081,092.45	1,114,686,137.83	1,598,985,807.28
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	164,218,577.00	320,081,092.45	1,114,686,137.83	1,598,985,807.28
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,218,577.00	320,081,092.45	1,114,686,137.83	1,598,985,807.28
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,315,969.32	2,315,969.32
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,218,577.00	320,081,092.45	1,117,002,107.15	1,601,301,776.60

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	527,726,800.00	537,079,942.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	527,726,800.00	537,079,942.90
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	442,847,600.00	470,616,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,646,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,646,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,233,200.00	66,463,242.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,233,200.00	66,463,242.90
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	520,920,300.00	537,079,942.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	520,920,300.00	537,079,942.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	494,515,290.77	529,279,749.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	334,309,733.08	345,433,505.58
210101	Үндсэн цалин	270,363,233.08	277,829,623.75
210102	Нэмэгдэл	40,699,300.00	37,424,597.41
210104	Урамшуулал	23,247,200.00	30,179,284.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,020,900.00	46,250,700.00
210201	Тэтгэврийн даатгал	28,574,200.00	32,301,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,361,700.00	3,487,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,689,400.00	2,789,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	672,300.00	697,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,723,300.00	6,974,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,638,908.69	62,963,242.90
210301	Гэрэл, цахилгаан	3,114,672.93	2,268,921.96
210302	Түлш, халаалт	53,975,516.76	51,203,960.94
210303	Цэвэр, бохир ус	9,548,719.00	9,490,360.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,211,750.00	17,817,520.82
210401	Бичиг хэрэг	486,500.00	455,200.00
210402	Тээвэр, шатахуун	900,000.00	1,250,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,411,400.00	1,147,370.82
210404	Ном, хэвлэл	245,400.00	488,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,926,900.00	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,241,550.00	14,226,950.00
2105	Нормативт зардал	37,355,599.00	26,188,180.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,598,400.00	630,600.00
210502	Хоол, хүнс	32,296,899.00	14,860,960.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,460,300.00	10,696,620.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,323,300.00	12,764,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	6,000,000.00
210604	Урсгал засвар	2,323,300.00	6,764,400.00

**Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2107	Томилолт, зочны зардал	168,000.00	160,900.00
210702	Дотоод албан томилолт	168,000.00	160,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,046,900.00	10,721,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	777,900.00	10,140,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	269,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	231,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,440,200.00	6,979,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	5,600,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,440,200.00	1,379,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,405,009.23	7,800,193.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,356,800.00	1,172,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,646,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	710,800.00	1,172,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,594,291.31	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,594,291.31	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,453,917.92	6,627,793.60
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,453,917.92	6,627,793.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	6,806,500.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	6,806,500.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,806,500.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,806,500.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,806,500.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-6,806,500.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	540,261,100.00	530,452,149.30	9,808,950.70	98.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	540,261,100.00	530,452,149.30	9,808,950.70	98.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	539,088,700.00	529,279,749.30	9,808,950.70	98.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350,367,200.00	345,433,505.58	4,933,694.42	98.59
210101	Үндсэн цалин	277,986,900.00	277,829,623.75	157,276.25	99.94
210102	Нэмэгдэл	39,242,000.00	37,424,597.41	1,817,402.59	95.37
210104	Урамшуулал	33,138,300.00	30,179,284.42	2,959,015.58	91.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,250,700.00	46,250,700.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	32,301,100.00	32,301,100.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,487,400.00	3,487,400.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,789,900.00	2,789,900.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	697,500.00	697,500.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,974,800.00	6,974,800.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,534,400.00	62,963,242.90	2,571,157.10	96.08
210301	Гэрэл, цахилгаан	3,799,200.00	2,268,921.96	1,530,278.04	59.72
210302	Түлш, халаалт	51,263,200.00	51,203,960.94	59,239.06	99.88
210303	Цэвэр, бохир ус	10,472,000.00	9,490,360.00	981,640.00	90.63
2104	Хангамж, бараа материалын зардал	17,853,500.00	17,817,520.82	35,979.18	99.80
210401	Бичиг хэрэг	455,200.00	455,200.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	1,250,000.00	1,250,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,433,300.00	1,147,370.82	285,929.18	80.05
210404	Ном, хэвлэл	486,200.00	488,000.00	-1,800.00	100.37
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	250,000.00	250,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,978,800.00	14,226,950.00	-248,150.00	101.78
2105	Нормативт зардал	27,837,300.00	26,188,180.00	1,649,120.00	94.08
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	630,600.00	630,600.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	16,508,600.00	14,860,960.00	1,647,640.00	90.02
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,698,100.00	10,696,620.00	1,480.00	99.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,764,400.00	12,764,400.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	6,764,400.00	6,764,400.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	160,900.00	160,900.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	160,900.00	160,900.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,340,800.00	10,721,800.00	619,000.00	94.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,750,800.00	10,140,800.00	610,000.00	94.33
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	231,000.00	9,000.00	96.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6979500.00	6979500.00	0.00	100.00

**Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,600,000.00	5,600,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,379,500.00	1,379,500.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1172400.00	1172400.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,172,400.00	1,172,400.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,172,400.00	1,172,400.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	540,261,100.00	530,452,149.30	9,808,950.70	98.18
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	471,226,700.00	463,988,906.40	7,237,793.60	98.46
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	471,226,700.00	463,988,906.40	7,237,793.60	98.46
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	69,034,400.00	66,463,242.90	2,571,157.10	96.28
132001	Орон нутгийн төсвөөс	69,034,400.00	66,463,242.90	2,571,157.10	96.28
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	32.00	32.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	0.00	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	229.00	229.00	0.00	100.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	229.00	229.00	0.00	100.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	229.00	229.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	32.0	32.0	0.00	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	19.00	19.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13.00	13.00	0.00	100.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан зааврын дагуу анхан шатны баримтыг хөтлөх, төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөх, эд хөрөнгийн тооллогын баримт материалыг Төрийн аудитын байгууллагад бүрэн ирүүлэх зэрэг зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг Д.Мөнхзул, 2 дугаар гарын үсгийг 1-2, 8-12 дугаар сард Г.Чулуунцэцэг, 3-7 дугаар сард Б.Оюундарь нар зурж, нярваар 2021 оны 1-7 сар хүртэлх хугацаанд Р.Энхцэцэг, 8-12 сар хугацаанд А.Оюунчимэг ажиллажээ.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэг нь цэцэрлэгийн зөвлөл, захиргаа аж ахуй, багш нарын зөвлөл, заах аргын нэгдэл гэсэн бүтэцтэй 32 орон тоотой, 8 бүлэгт 176 хүүхэдтэй зайн болон цахимаар үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын 2018.04.23-ний өдрийн 21 дүгээр тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдсөн ба 2021 онд аймгийн хэмжээнд мөрдөгдөх 300.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг авсан байна.

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй, бусад хяналт шалгалтын байгууллагуудаас шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн

тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 561,838.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,618.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,494.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 550,344.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,480.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,384.0 мянган төгрөг байгаа тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,601,301.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 2,316.0 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	82,760.6	131,781.3	49,020.7
Авлага	-	7,620.0	7,620.0
Бараа материал	82,760.6	124,161.3	41,400.7
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,516,225.2	1,469,520.5	(46,704.7)
Үндсэн хөрөнгө	1,611,712.3	1,613,197.8	1,485.5
Хуримтлагдсан элэгдэл	(95,487.2)	(143,677.4)	(48,190.2)
Нийт хөрөнгө	1,598,985.8	1,601,301.8	2,316.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,598,985.8	1,601,301.8	2,316.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,598,985.8	1,601,301.8	2,316.0

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Цэцэрлэгийн барилгын засварын ажлын зураг төсвийн үнийг 16,560.9 мянган төгрөгөөр хийлгэх гэрээг "Цэсда" ХХК-тай цэцэрлэгийн эрхлэгч 2021.12.20-ний өдөр байгуулж, 2021.12.24-ний өдөр гэрээнд заасан урьдчилгаа төлбөрт 7,620.0 мянган төгрөгийг шилжүүлж, ажлыг бүрэн гүйцэтгээгүй байхад санхүүгийн тайланд авлагаар тусаагүй зөрчил илэрсэн тул санхүүгийн тайланд авлагаар залруулав.

Бараа материалын дансны үлдэгдэл 124,161.3 мянган төгрөг болж өмнөх оноос 41,400.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 61,350.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 5,680.9 мянган төгрөгийн бараа материал, эцэг эхчүүдээс хандиваар өгсөн бараа материалыг орлогод авч, үйл ажиллагаандаа 29,250.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, байгууллагын даргын 2021.06.18-ний өдрийн А/20 дугаар тушаалаар 78 төрлийн 1,660.5 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг акталж, Баянхонгор сумын Засаг даргын захирамжаар Баян-Ойт цэцэрлэгт 27.5 мянган төгрөгийн хүнсний материалыг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Оны эхэнд бүртгэлтэй 1,611,712.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр нэмж аймгийн ЗДТГ-аас 550.0 мянган төгрөгийн өнгөт принтер, 1,725.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер ирснийг хөрөнгөд бүртгэн, Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.10.15-ний өдрийн 116 дугаар тогтоолоор 789.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, оны эцэст 1,613,197.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 2,315.9 мянган төгрөгөөр өсөж 1,601,301.7 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү, өмнөх оны үр дүн өөрчлөгдөөгүй бөгөөд тайлант жилийн үр дүн тайлангуудад зөв бүртгэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэг 2021 оны төсвийн төлөвлөлтийг 649,246.3 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71801 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэх төсвийн хуваарийг анх 581,544.5 мянган төгрөгөөр баталсан ба тайлант хугацаанд 2021 оны 4 дүгээр сард 567,912.8 мянга, 7 дугаар сард 567,300.5 мянга, 11 дүгээр сард 540,261.1 мянган төгрөг болж, анх батлагдсан төсвөөс 41,283.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Анхны батлагдсан төсөв	2021 оны 12 сард хийсэн тодотгосон төсөв
581,144.4	540,261.1

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэг өөрийн орлогын төлөвлөгөөгүй, тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр авахаар батлагдсан 471,226.7 мянган төгрөгийн санхүүжилтээс 610,0 мянга, орон нутгийн төсвөөс авахаар батлагдсан 69,034.4 мянган төгрөгийн дэмжлэгээс 2,571.2 мянган төгрөгөөр дутуу авч, нийт 537,079.9 мянган төгрөгийн санхүүжилт авснаас 530,452.1 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 6,627.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт төсөв байхгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хоолны зардлын хэмнэлтийг бага үнэтэй түргэн элэгдэх зүй худалдан авах зардалд тодотгуулан 2021 оны 10 дугаар сард “Окфил эко” ХХК-аас нэг бүр нь 106.0 мянган төгрөгийн үнэ бүхий 80 ширхэг агаар шүүгчийг 8,480.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Мөн 12 дугаар сард хоолны зардлын хэмнэлтээс урсгал засварын зардалд төсөв батлуулж, "Алтайн гурван нуур" ХХК-д 6,000.0 мянга, "Ерөөл нэмэх" ХХК-д 1,770.0 мянган төгрөгийг шилжүүлж, байгууллагын гадна талын тохижилтын ажлыг хийж гүйцэтгэн, "Next electronics" ХХК-аас 2,559.2 мянган төгрөгийн 8 ширхэг тоос сорогч худалдан авсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага "Аргачлал, загвар батлах тухай" Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу тайлант онд 5 үндсэн зорилтын хүрээнд 39 арга хэмжээг төлөвлөн амжилттай хэрэгжүүлж, оны эцэст биелэлтийг 96%-тай тайлагнасан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг шалгав.

Тус байгууллага нь 2021 онд нийт 707,603.4 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхийг бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, ТБОНӨХБАҮХАТХ болон Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын зарим чиглэлийг хэрэгжүүлж ажиллаагүй нь холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэн зөвлөмжийг хүргүүлэв.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Г.Ганчимэг гүйцэтгэж, менежментийн захидлаар 3 зөвлөмж өгч, 1,603,3 мянган төлбөрийн акт тогтоосныг шалгагдагч байгууллага бүрэн биелүүлж,

зөвлөмжийн биелэлтийг 2021.06.15-ний өдрийн 49 дугаартай албан бичгээр Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,692.6 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, санхүүгийн тайланд 7,620.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1,072.6 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн санхүүгийн тайланд дараах алдааг залруулав.

1. Цэцэрлэгийн барилгын засварын ажлын зураг төсвийн үнийг 16,560.9 мянган төгрөгөөр хийлгэх гэрээг "Цэсда" ХХК-тай цэцэрлэгийн эрхлэгч 2021.12.20-ний өдөр байгуулж, 2021.12.24-ний өдөр гэрээнд заасан урьдчилгаа төлбөрт 7,620.0 мянган төгрөгийг шилжүүлж, ажлыг бүрэн гүйцэтгээгүй байхад санхүүгийн тайланд авлагаар тусаагүй зөрчил илэрсэн тул санхүүгийн тайланд авлагаар залруулав.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Балансын данстай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт: Тайлант онд тогтмол зардалд 65,534.4 мянган төгрөгийн төсөв батлагдсан байхад 62,963.2 мянган төгрөгийг зарцуулж "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.8 дахь "Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-оос доошгүй хувийн хэмнэлт гаргах", бичиг хэргийн зардалд батлагдсан 455.2 мянган төгрөгийг зарцуулж тогтоолын 1.9 дэх "Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах" заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах

2. *Зардлын холбоотой асуудал*

2.1. Илрүүлэлт: Анхан шатны баримтыг батлагдсан маягтын дагуу хөтлөөгүй, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: "Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар"-ын дагуу анхан шатны баримтыг хөтлөх, төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж, бүртгэл хөтлөлтөд тавих нягтлан бодогчийн хяналтыг сайжруулах.

3. *Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал*

3.1. Илрүүлэлт: Жилийн эцсийн тооллогын комисс тооллогын дүнг хэлэлцсэн хурлын тэмдэглэлд хөрөнгийн дүнг зөрүүтэй танилцуулсан, тооллогын баримт материалыг Төрийн аудитын байгууллагад дутуу ирүүлсэн.

3.2. Өгсөн зөвлөмж: Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын дүн, чанар, ашиглалтын байдлын хөтлөлтийг сайжруулан, Төрийн аудитын байгууллагад эд хөрөнгийн тооллогын баримт материалыг бүрэн ирүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэг	3	8,692.6	1	7,620.00	0	0	0	-	2	1,072.6

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo---